



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/257

Улаанбаатар хот

Хураамж тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Чингис хаан” Олон улсын шинэ нисэх буудалд нислэг үйлдэх гадаад, дотоодын агаарын тээврийн компаниудын агаарын хөлөгт үзүүлэх гэрэл-суултын системийн хураамжийг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Санхүү, эдийн засаг, төлөвлөлтийн газар (Б.Батхишиг), Агаарын навигацийн үйлчилгээний газар (Э.Төрбаяр), Холбоо, навигаци, ажиглалтын алба /М.Эрдэнэсүх/-нд тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төвийн дэд дарга (Н.Мягмарсүрэн)-д даалгасугай.


4. Энэ тушаалыг 2021 оны 7 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын
2021 оны 07 дугаар сарын 08 -ны өдрийн
А/257 дугаар тушаалын хавсралт



ГЭРЭЛ-СУУЛТЫН СИСТЕМИЙН ХУРААМЖ

Хураамжийн тооцоо хийх суурь: Агаарын хөлгийн хөөрөлтийн дээд хүндийн жин (MTOW)

А. Олон улсын чиглэлд нислэг үйлдэх гадаадын агаарын тээврийн компаниудын агаарын хөлгөөс:

| Аэродром | Хураамжийн хэмжээ (ам.дол-аар) MTOW-ийн тонн тутмаас |
|---|---|
| “Чингис хаан” Олон улсын нисэх буудал дахь аэродромын гэрэл-суултын системийн хураамж | 3.0 |

Б. Олон улсын чиглэлд нислэг үйлдэх үндэсний агаарын тээврийн компаниудын агаарын хөлгөөс:

| Аэродром | Хураамжийн хэмжээ (төг-өөр) MTOW-ийн тонн тутмаас |
|---|--|
| “Чингис хаан” Олон улсын нисэх буудал дахь аэродромын гэрэл-суултын системийн хураамж | 3,000.0 |

В. Орон нутгийн чиглэлд нислэг үйлдэх дотоодын агаарын тээврийн компаниудын агаарын хөлгөөс:

| Аэродром | Хураамжийн хэмжээ (төг-өөр) MTOW-ийн тонн тутмаас |
|--|--|
| “Чингис хаан” Олон улсын нисэх буудалд | 550.0 |

Тайлбар:

- гэрэл-суултын системийн хураамжийг агаарын хөлөг бууж, хөөрөхөд нэг удаа тооцож авна;
- гэрэл-суултын системийг өдрийн цагаар шаардлагатай үед ашигласан нөхцөлд төлбөрийг энэхүү тарифаар тооцно.